



“ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК



БАТЛАВ  
ДДЦС ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
М. ЖАРГАЛСАЙХАН

2024 оны 08 сарын 27 өдөр

## АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

**ТГ№4-ИЙН ИХ ЗАСВАР**

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

**ДДЦСТ/20240101100**

ДАРХАН-УУЛ АЙМАГ

2024 он

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	7
1. Тендерийн цар хүрээ .....	7
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг .....	7
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж .....	7
4. Худалдан авах ажиллагааны цахим систем .....	7
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх .....	7
6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага .....	7
7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага .....	8
Б.АГУУЛГА .....	8
8. Тендер шалгаруулалтын баримт бичиг .....	8
9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах .....	9
10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт .....	9
11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах .....	9
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ .....	9
12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл .....	9
13. Тендерийн иж бүрдэл .....	10
14. Тендерийн жишиг маягнууд .....	10
15. Хувилбарт санал.....	10
16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг .....	11
17. Чадавхын болон туршлагын шаардлага .....	11
18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт .....	11
19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт .....	12
20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг .....	12
21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт .....	12
22. Тендерийн валют .....	13
23. Тендер хүчинтэй байх хугацаа.....	13
24. Тендерийн баталгаа .....	13
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ.....	14
25. Тендер баталгаажуулах, илгээх.....	14
26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа .....	14
Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ .....	14

27.	Тендерийн талаар тодруулга авах.....	14
28.	Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх .....	14
29.	Тендерийг үнэлэх .....	15
30.	Арифметик алдааг залруулах.....	15
31.	Давуу эрх олгох .....	15
32.	Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт .....	15
33.	Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох.....	15
34.	Тендерийг эрэмбэлэх .....	15
35.	Оролцогчийн чадавхыг дахин магадлах .....	15
<b>Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ .....</b>		<b>16</b>
36.	Мэдэгдэл хүргүүлэх .....	16
37.	Гүйцэтгэлийн баталгаа .....	16
38.	Урьдчилгаа төлбөр .....	16
39.	Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах.....	16

## I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

### А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ
  - 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “ажил” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана.
  - 1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
  - 1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана.
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг
  - 2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана.
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж
  - 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
4. Худалдан авах ажиллагааны цахим систем
  - 4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх
  - 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.
  - 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага
  - 6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.
  - 6.2. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3.Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

#### Б.АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3.Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер

- бэлтгэнэ.
9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах
- 9.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.
- 9.2. Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.
- 9.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.
- 9.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.
- 9.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.
10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт
- 10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.
- 10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.
11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах
- 11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.
- 11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.
- В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**
12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл
- 12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

### 13. Тендерийн иж бүрдэл

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

### 14. Тендерийн жишиг маягтууд

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

### 15. Хувилбарт санал

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг

тендерийн хамт ирүүлж болно.

## 16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг

16.1.Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2.Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3.Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4.Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

## 17. Чадавхын болон туршлагын шаардлага

17.1.Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2.Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3.Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4.Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5.Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

## 18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох

18.1.Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага



баримт

хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт

19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3. Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

20.1. Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2. Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх

бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.

21.3.Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.4.ТШЗ-ны 21.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.

21.5.ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.6.Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.7.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

## 22. Тендерийн валют

22.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

## 23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1.Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2.Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

## 24. Тендерийн баталгаа

24.1.Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах

ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2.Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.3.Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

#### Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1.Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2.ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3.Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт **Error! Reference source not found.**7-ын дагуу н ууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5.Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1.Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2.Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

#### Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах

27.1.Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1.Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар

- авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.
29. Тендерийг үнэлэх
- 29.1. Хуулийн 11.4-т зааснаар захиалагч үнэлгээний үндсэн шалгуурыг сонгох бөгөөд өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол үнэлгээний үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 29.2. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.3. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
30. Арифметик алдааг залруулах
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
31. Давуу эрх олгох
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн бол хуулийн 8.4, 8.7-т зааснаар үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт
- 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
34. Тендерийг эрэмбэлэх
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.
35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног

төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан эсэхийг дахин магадална.

35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

#### Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

36. Шийдвэр хүргүүлэх 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
37. Гүйцэтгэлийн баталгаа 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
38. Урьдчилгаа төлбөр 38.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 38.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.
- 38.3. Урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38.4. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.
39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах 39.1. Захиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 39.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: <b>“Дарханы Дулааны Цахилгаан Станц” ТӨХК</b>
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: <b>ТГ№4-ийн их засвар.</b>
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: <b>ДДЦСТ/20240101100</b>
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцгүй.</b>
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: <b>“Үгүй”</b>
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Өөрийн хөрөнгө.</b>
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: <b>385,575,261.00 ( гурван зуун наян таван сая таван зуун далан таван мянга хоёр зуун жаран нэг) төгрөг.</b>
Б. АГУУЛГА	
ТШЗ 9.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: <b>Ерөнхий инженер Б. Хаш-Эрдэнэ</b> Хаяг: <b>Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р баг, үйлдвэрийн район, “Дарханы Дулааны Цахилгаан Станц” ТӨХК-ийн байр, 3-р давхар, 302 тоот.</b> Утасны дугаар: <b>70373126</b> Цахим шуудангийн хаяг: <b>darhanpp@mongol.net</b>
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <b>“Үгүй”</b>
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: <b>Монгол хэл.</b>
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>“Зөвшөөрөхгүй”</b>
ТШЗ 16.1.2	<b>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана”</b> <b>1. Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ. Тендер нээсэн өдрийн байдлаар татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн талаархи мэдээллийг шалгана.</b> <b>2. Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй хүчин төгөлдөр лавлагааг цахим системээс авч, зааварчилгааны дагуу цахим системээр холбогдох талбараар ирүүлнэ.</b>

	<p>3. Хүчин төгөлдөр эрх бүхий төсөвчингийн хийсэн, шууд ба шууд бус зардлууд, нормчлолын сангийн шимтгэл, захиалагчийн техникийн хяналтын зардал, магадлашгүй ажил, татваруудыг бүрэн тусгасан төсвийг ирүүлнэ.</p> <p>4. Их засварын ажлыг гүйцэтгэх хуваарийг ирүүлнэ.</p>
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: <b>“Шаардана”</b></p> <p>1. Борлуулалтын орлогын хэмжээ: 2021, 2022, 2023 онуудын жил бүрийн борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас их байна.</p> <p>2. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас хувиас багагүй байна.</p> <p>3. Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна.</p>
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <p>1. 2021, 2022, 2023 онуудын буюу сүүлийн гурван жилийн хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан; аудитын дүгнэлт.</p> <p>2. 2021, 2022, 2023 онуудын буюу сүүлийн гурван жилийн хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл. Тендерт оролцогчийн борлуулалтын орлогийн мэдээллийг Сангийн яамны санхүүгийн тайлангийн мэдээллийн систем дэхь санхүүгийн тайлангаас шалгана</p> <p>3. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээг нийт дүнг дараахь шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тодорхойлно. Үүнд: -Харилцагч банкны дансны үлдэгдэл -Харилцагч банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт -Үнэт цаас, ЗГ-ын бонд.</p> <p>4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн” бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. (“Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг <a href="http://www.sainscore.mn">www.sainscore.mn</a>, <a href="http://www.burenscore.mn">www.burenscore.mn</a> хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй.)</p>
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: <b>“Шаардана”</b></p> <p>Ажил гүйцэтгэх хүний нөөц: <b>“Шаардана”</b></p>

**Ажлыг гүйцэтгэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаархи мэдээллийг ирүүлэх.**

1. Ажил гүйцэтгэх хүний нөөц:

№	Албан тушаал	Ажилтны тоо	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Мэргэжлээр ээ ажилласан жилийн туршлага
1	Ерөнхий инженер	1	Дулааны инженер	8 жилээс доошгүй
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны гэрчилгээтэй байна.	5 жилээс доошгүй
3	Дулааны инженер, механик инженер	2-оос доошгүй	Дулааны инженер, механик инженер	5 жилээс доошгүй
4	Оосорлогч, дохиочин	1-ээс доошгүй	Оосорлогч, дохиочны гэрчилгээтэй байна.	5 жилээс доошгүй
5	Гагнуурчин, категори 1.1, 1.2	1-ээс доошгүй	Гагнуурчин	5 жилээс доошгүй
6	Эргэх механизмын засварчин 5,6-р зэрэгтэй	3-аас доошгүй	Эргэх механизмын засварчин	5 жилээс доошгүй
7	хаалт арматурын засварчин 5,6-р зэрэгтэй	5-аас доошгүй	хаалт арматурын засварчин	5 жилээс доошгүй
8	Өрлөг дулаалгын засварчин, 4,5-р зэрэгтэй	3-оос доошгүй	Өрлөг дулаалгын засварчин	5 жилээс доошгүй

Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: **“Шаардана”**

2. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл:



№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг
1	Турбины их засвар, тусгай зориулалтын багаж хэрэгсэл		-
2	Авто машин	1 тн болон түүнээс дээш	1

3. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: **“Шаардана”**

**Ижил төстэй ажил гэдэгт Дулааны цахилгаан станцын уурын турбины их засвар хамаарна.**

Сүүлийн 3 жилд буюу 2021, 2022, 2023 онуудад жил бүр батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 80 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын гүйцэтгэгчээр ажилласан байна.

4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: **“Шаардана”**

ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <p><b>1. Ажил гүйцэтгэх хүний нөөцийн шаардлагыг нотлох дараахь баримт бичиг ирүүлнэ.</b>  <b>Үүнд:</b>  <b>а)Тендерт оролцогч нь ажилтны мэдээллийг цахим систем дэхь V бүлэгт заасан маягтаар зааварчилгааны дагуу санал болгоно.</b>   <b>б) Ажилтны сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлнэ. Шаардлагатай бол Төрийн мэдээлэл, солилцооны ХУР системээр дамжуулан Боловсрол, Шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. /Тендерт оролцогч нь Төрийн үйлчилгээний нэгдсэн системд ажилтны дээд боловсролын дипломын мэдээлэл байршсэн эсэхийг урьдчилан шалгана уу/.</b>   <b>в) Тендерт оролцогчийн ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг цахим системээр дамжуулан шалгана.</b>   <b>г)Мэргэшсэн, зөвлөх зэрэгтэй ажилтан, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан, Оосорлогч, дохиочин зэрэг ажилтнуудын хүчин төгөлдөр мэргэжлийн гэрчилгээний хуулбарыг тендерт хавсарган ирүүлнэ. Тухайн ажлын гэрээний гүйцэтгэлд дээрх санал болгосон ажилтнаас өөр ажилтнаар ажил гүйцэтгүүлсэн тохиолдолд илт худал мэдээлэл бүхий тендер гэж үзэн эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах нөхцөл болохыг анхаарна уу.</b></p> <p><b>2. Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг нотлох дараахь баримт бичиг ирүүлнэ.</b>  <b>Үүнд:</b></p>
----------	---

	<p><i>а) Тендерт оролцогч өөрийн машин механизм, тоног төхөөрөмжийг цахим систем дэхь V бүлэгт заасан маягтаар зааварчилгааны дагуу санал болгоно.</i></p> <p><b>3. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох дараахь баримт бичиг ирүүлнэ.</b>  <b>Үүнд:</b>  <i>а) Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын шаардлагыг хангах ажил гүйцэтгэсэн гэрээ, гэрээ дүгнэсэн акт.</i></p> <p><b>4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх нотлох дараахь баримт бичиг ирүүлнэ.</b>  <b>Үүнд:</b>  <i>а)Өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан ажлын гүйцэтгэлийн явцын талаархи мэдээллийг ирүүлнэ.</i></p>
ТШЗ 19.3	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <b>“Шаардана”</b></p> <p>Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага: <b>Эрчим Хүчний Яам</b></p> <p>Тусгай зөвшөөрлийн нэр:  <b>4.3: 0,7-80 кгс/см<sup>2</sup> даралттай даралтат савны угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ</b></p> <p>эсхүл</p> <p><b>7.2: 40.0 кгс/см<sup>2</sup>-аас дээш даралтанд ажилладаг тоноглолын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ.</b></p>
ТШЗ 21.6	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“Тохируулахгүй тогтмол байна”</b>
ТШЗ 24.1	Тендерийн баталгааны дүн: <b>1,927,877(нэг сая есөн зуун хорин долоон мянга найман зуун далан долоо) төгрөг.</b>
<b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b>	
ТШЗ 25.5	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ol style="list-style-type: none"> <li><b>1. Тендерт ирүүлсэн төсвийн товчоо</b></li> <li><b>2. Ажил гүйцэтгэх хуваарь,</b></li> <li><b>3. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ.</b></li> <li><b>4. НӨАТ-ын өргүй тодорхойлолт</b></li> <li><b>5. Шүүхийн ерөнхий зөвлөлийн тодорхойлолт.</b></li> <li><b>6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт.</b></li> <li><b>7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалтыг Маягт 8-ын дагуу ирүүлнэ..</b></li> </ol>
ТШЗ 26.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <b>2024 оны 03 дугаар сарын 05-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10цаг 30 минут.</b></p>
ТШЗ 26.2	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: <b>2024 оны 03 дугаар сарын 05-ны өдөр</b></p>

	<p>Цаг: <b>11 цаг 00минут.</b></p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р баг, Үйлдвэрийн район, “Дарханы Дулааны Цахилгаан Станц” ТӨХК-ийн байр, 3 дугаар давхар 302 тоот</p>
<p><b>Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ</b></p>	
ТШЗ 31.1	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: <b>Үгүй.</b>
ТШЗ 32.1	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: <b>Үгүй.</b>
<p><b>Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b></p>	
ТШЗ 37.1	<p>Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <b>“Тийм”</b></p> <p>Гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ. <b>Гүйцэтгэлийн баталгааны дүн: 11,657,258.00 (арван нэгэн сая зургаан зуун тавин долоон мянга хоёр зуун тавин найм) төгрөг.</b></p>
<p><b>Ё. БУСАД</b></p>	
ТШЗ 38.1	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: <b>“Үгүй”.</b>

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА


 БАТЛАВ  
 "ДДЦС" ТӨХК-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  
 Б.ХАШ-ЭРДЭНЭ  
 ОНЫ 10-р сарын 30-нд өдөр

#### Турбингенератор №4-ийн 2024 оны графикт Их засварын ажлын эзэлхүүн

2020 оны их засвараас хойш нийт 16124 цаг ажилласан

1. Бэлтгэл ба төгсгөл ажлууд				
№	хийгдэх ажлын нэр	ХЭМ/НЭГЖ	Тоо	Тайлбар
1	Их засвар хийх ажилтнуудад ААД, ТАД-ээр зааварчилгаа өгөх / акт формуляр бэлтгэх, хөтлөх /	удаа	1	
2	Турбинд гадаад үзлэг хийж засварт хүлээж авах	удаа	1	
3	Ажлын байр талбайг бэлдэж материал татан авах	удаа	2	
4	Багаж хэрэгслээ татаж, ажлын байраа цэвэрлэж цэгцлэх.	өдөр бүр	1	
5	Ротор өргөх ба крышка өргөх төхөөрөмжүүдэд үзлэг хийж бэлтгэх.	удаа	2	
6	Тос шахаж шалгах, системийн тосыг шүүж цэвэрлэх.	удаа	1	
7	Тохируулгын системийг явалт дунд нь шалгаж зүгшрүүлэх	удаа	1	
8	Турбиныг явуулж турших хамгаалалт шалгах.	удаа	1	
9	Турбиныг 72 цаг ажиллуулсны дараа гэмтэл устгах	удаа	1	
10	Засвартай холбоотой бүх акт, протокол, тайланг гаргаж өгөх	удаа	1	
2. Тохируулгын болон хамгаалалтын систем.				
11	Урд блокны хэвтээ заадсын (разъём) нягтыг цинк будаг түрхэн шалгах, хусч нягтруулах	удаа	1	
12	Урд блокны дээд хэвтээ заадсыг тайлж импульсын шугам салгах, разъёмыг хусаж цэвэрлэх, гараар шайбердах өнгөлж билүүдэх аргаар нягтыг сайжруулах	удаа	1	
13	Хурдны ба отборуудын тохируулагчыг задлаж, үзлэг хийх угсарч байрлуулах тос гоожиж байгаа гэмтлийг арилгах	удаа	3	
14	Синхронизатор авах үзлэг хийх угсрах.	ком	2	
15	АХА-г авч үзлэг хийх, угсрах, эргэлтээр туршиж боек тохируулах.	удаа	1	
16	Тосны даралтын трансформаторыг задлаж засварлах угсрах	удаа	2	
17	Зогсоох клапаны сервомотор задлах, засах угсрах.	удаа	2	
18	Хурдны ба даралтын хоёр тохируулагчын сервомотор таслах, золотникт үзлэг засвар хийх угсрах	удаа	2	
19	Эргэх диафрагмын сервомотор задлах үзлэг засвар хийж угсрах	удаа	2	
20	Тохируулгын нугасан холбоосуудыг задлаж үзлэг хийх эргүүлж угсрах. Сул явалтыг арилгах	удаа	2	
21	Блокны дотор талыг цэвэрлэх уурдаж үлээлгэх./дунд заадсаар салгаж/	удаа	1	
22	Тохируулгын блокыг байрлуулж шугам холбох.	удаа	1	

23	Золотникийн сүмбэн голны өндөр, ба таслагчийн нударганы өндөр, байрлалыг тохируулах.	удаа	1	
24	Зогсоох клапанд өнгөлгөө хийж нягтруулах. Ф=200мм	ш	2	
25	Стопорный клапангийн тосон талын резьбатай голд үзлэг засвар хийх. Шаардлагатай бол солих	ш	2	
<b>3. Уур хуваарилах байгууламж</b>				
26	Стопорный клапаны зүрх болон хацар араанд үзлэг засвар хийх.	ш	4	Зүрх араа 1ш, хацар араа 1ш байдаг.
27	Хөшүүргэн холбоосуудыг салган авч үзлэг хийх угсрах.	ш	3	
28	Уур хуваарилах байгууламжийн разъемны боолтыг сэргээж, шаардлагатайг солино. (М36-ын 32ш болт)	ш	32	М36-ын боолт
29	IX ба X тохируулах клапангаас буух шугамуудыг тайлж авч цэвэрлэх резьба сэргээж эргүүлэн боох	удаа	2	М27-ын 32ш боолт
30	Зогсоох клапаны разгрузочный клапангуудыг авч өнгөлөх. Угсрах	удаа	2	
31	Тохируулах клапангуудыг солих. Бат бөх бэхэлсэн байдлыг шалгах	ш	10	
32	П болон Т отборын цагираг диафрагммыг задлах, засах, угсрах.	удаа	2	
33	Тохируулах клапангийн штокын нягтруулагч ган кольцуудыг засварлах.	ш	12	
34	Тохируулах клапангуудын шилбэний уртаар явалтыг тохируулах.	ш	10	
35	Тохируулах клапаны хөшүүргийн хөдөлгөөнийг арилгах засварлах.	ш	1	
36	Урд, хойд стопорный клапангийн ууран талын голыг солих	ш	2	
<b>4. Эргэвчүүдийн засвар</b>				
37	Эргэвчүүдийн таг нээх, их биеийг цэвэрлэх, тагны натяг шалгаж тохируулж, байрлуулж боох.	ш	6	
38	Холхивчуудын подгонка тааруулах	ш	6	
39	Зазор шалгах, суултыг шайбердаж, тааруулах, барьцалдааг шалгах чиглүүлэгч ба бэхэлгээг шалгах, I холхивчийн хэвтээ разъемыг гараар шайбердаж нягтыг сайжруулах	ш	6	
40	Барих эргэвчийг задлаж үзлэг хийх баббитын хүрэлцээг будгаар шалгах, цагаригт угсарч солих шаардлагатай эсэхийг тодорхойлох.	ш	6	
41	Эргэвчийн тосны зайг хэмжиж, шаардлагатайг солих зазорыг тохируулан угсрах	ш	6	
42	Вкладышны тулах дэрний зузааныг тохируулах хүрэлцээг сайжруулах	ш	6	
43	IY эргэвчийн бөмбөрцөг гадаргуугын хүрэлцээг шалгах. Ф=350мм	ш	1	
44	1,2,3,4-р холхивчийг шинээр цутгах, тохируулга хийх	ш	4	
45	4 -р холхивчийн хөнгөн цагаан нягтруулагчид /том, жижиг / үзлэг хийж засварлах.шаардлагатай бол солих	ком	2	

46	5-р холхивчийн хөнгөн цагаан нягтруулагчид үзлэг хийж засварлах.шаардлагатай бол солих.	ком	2	
47	6-р холхивчийн хөнгөн цагаан нягтруулагчид үзлэг хийж засварлах.	ком	1	
48	Дэрний зузааныг тааруулах үед муфт ба нягтруулагчаар роторыг төвлөрүүлэх	удаа	1	
49	Тулах эргэвчийн цагаригын /подкладка/ тусламжтайгаар голын гүйлт тааруулах	удаа	1	
50	Тулах колодкын засвар тохиргоог шинэчлэн хийх	ш	10	
51	Ажлын, ажлын бус талын тулах колодкуудыг шинээр тохируулж солих	ш	10	
52	Эргэвчүүдийн тагны разъем хусаж тааруулах боолт, гайкыг сэргээн засварлах	ш	6	
<b>5. Гол эргүүлэх байгууламжийн засвар.</b>				
53	ГЭБ-ыг задлах үзлэг хийх, засварлах	ком	1	
54	Поршенгийн удирдлагын 2 эгнээ цонхтой буксыг цэвэрлэж угсрах.	ш	1	
55	ГЭБ-тай харьцах арааны харьцааг түлхэгчийн уртад тааруулан шавуулж тохируулах.	ш	1	
56	ГЭБ-ийн хумсанд үзлэг хийж, засварлах буюу солих	ш	1	
57	Бүх М24-ын боолтны резьбаг сэргээж шинээр татах	ш	32	
<b>6. Муфтны засвар</b>				
58	РГ-РТ-ны муфтыг задлах бүх боолтны резьба сэргээх урагдсан нүхийг засах буцааж боох,	ш	10	
59	Муфтны боолтны жин ба суултыг тааруулах.	ш	10	
60	Генераторын хагас муфтны хацарын цохиог хусаж тэгшлэх.	ш	1	
61	ТР, ГР-ын муфтний нүүрний цохиог тусгай багаж ашиглан тохируулах	удаа	2	
<b>7. Их биений засвар. (цилиндр)</b>				
62	Шат талбайг бэлдэж бүрээс задлах, эргүүлж угсрах.	ш	1	
63	Цилиндрийг нээх	ш	1	
64	Турбины крышка нээсний дараа засварын талбайд тусгай суурь (кантовка) бэлтгэж, дээш харуулан тавих	ш	1	
65	Сопло сегментүүдэд үзлэг хийж засварлах.	ком	1	
66	Разъем цэвэрлэх	удаа	1	
67	Разъёмын нягт шалгах. Гараар шайбердах хусах өнгөлөх зэргээр хэвтээ заадасын нягтыг сайжруулах	удаа	3	
68	Диафрагмуудыг байрнаас нь сугалан авч үзлэг хийх, нарийн зүлгүүрээр цэвэрлэх буцааж суулган бэхлэх.	ш	28	
69	Эргэх диафрагмыг дотор талаас нь зорж цилиндр хэлбэрт нь оруулах	удаа	2	
70	Эргэх диафрагмыг авч цэвэрлэх эргүүлж угсрах, боолтуудыг солих	удаа	2	
71	Диафрагмын чиглүүлэгч хүрзэн дээр тогтсон хаг хусмыг зүлгүүрдэж цэвэрлэх	ш	28	нэг диафрагмд 34-39 чиглүүлэгч хүрз байдаг

72	Сегментүүдийг сугалан авч цэвэрлэх сольж угсрах	удаа	2	
73	Борштанг ашиглан цилиндрийн расточек тааруулах	удаа	1	
74	Диафрагмын нягтруулагчын зайг шалгах, төвлөрүүлэлт хийх	удаа	16	
75	Өндөр даралтын нягтруулагчийн обоймыг дотор талаас нь хэв гажилтыг арилгах, төвлөрүүлэлт хийх. Расточкыг цилиндр хэлбэрт оруулах	удаа	2	
76	Урсгал хэсгийн зайг хэмжиж формуляр хөтлөх	удаа	1	
77	Роторыг цилиндрээс өргөх ба тавих	удаа	8	
78	Разъёмны шпилькүүдийг тайлж авах резъбаг сэргээх	ш	72	
79	Корпусын чиглүүлэгчүүдийн суултыг тааруулах	удаа	6	
80	Төгсгөлийн нягтруулагчийн хэв гажилтыг арилгах төвлөрүүлэх. Разъёмыг гараар шайбердах	удаа	1	
81	Диафрагмын бэхлэгээний боолтуудыг тайлж, хугарсныг ерөмдөж авах, резъбаг сэргээн тавих	ш	28	м12-ын далд толгойтой 28ш болт тайлж авна
82	П, Т отборын диафрагмын штокын нягтруулах цагирагуудад үзлэг хийж засварлах	удаа	6	
83	Цилиндрийг хаах	удаа	1	
84	Сүүлийн үеийн хамгаалах клапанд үзлэг засвар хийх. Нягтруулагч резинийг солих	удаа	2	Ду350 мм
85	Өндөр даралтын хэсгийн каминий хэв гажилтыг шалгаж зоруулж арилгах	удаа	1	
86	Нам даралтын хэсгийн каминийг зоруулж хэв гажилтыг арилгах	удаа	1	
87	Өндөр даралтын хэсгийн нягтруулгын объёмыг зоруулж хэв гажилтыг арилгах	удаа	2	
<b>8. Роторын угсралт, тохируулга</b>				
88	Урсгал хэсгийн тэнхлэгийн дагуу, болон радиусын дагуу зайг хэмжих, тохируулах	удаа	4	
89	Роторын төвлөрүүлэлтийг хагас муфтаар шалгах	удаа	2	
90	Роторын голын цохио үзэх	удаа	1	
91	Роторыг өргөж авах үзлэг засвар хийж байрлуулах	удаа	2	
92	Турбины роторын балансыг станок дээр шалгаж хэвийн болгох	удаа	2	
93	Генераторын роторын балансыг станок дээр шалгаж хэвийн болгох	удаа	2	
94	Тулах дискний ажлын ба ажлын бус талын цохиог хэмжих	удаа	2	
95	Тулах дискний ажлын ба ажлын бус талын торцийг өнгөлөх	удаа	2	0.01м2
96	Нягтруулгын усик солих	ш	108	өндөр талынх 82ш, нам талынх 26ш
97	Турбины роторын хүзүүнүүдийг өнгөлөх	ш	2	ф=180мм, ф=200мм
98	РГ-РТ -гийн хагас муфтаар төвлөрүүлэлт хэмжих	удаа	2	
99	Ажлын хүрээний бэхлэгдсэн байдлыг нэг бүрчлэн шалгах	удаа	1	

9. Тосны системийн засвар				
100	Тосны системийн шугам хоолойг задлах цэвэрлэх жийрэг сольж буцааж угсрах	удаа	2	Ф80мм
101	Тос хөргөгчийг задлах цэвэрлэх угсрах. Тосны орох, гарах 4ш хаалтанд үзлэг хийж засварлах	ш	4	Ру10 Ду80
102	Тос хөргөгчийн гуулин хоолойг бүрэн цэвэрлэх	ш	384	
103	Тос хөргөгчийн гуулин жийрэг солих	ш	2	
104	Тосны бакыг задлаж үзлэг хийх цэвэрлэж хаах	ш	1	
105	Тосны бакны шүүр цэвэрлэх	ш	2	
106	Тосны цахилгаан насосыг задлаж үзлэг, засвар хийх.	ш	1	
107	Шарикан клапангуудыг задлаж нягтыг шалгаж буцааж угсрах	удаа	3	
108	Ф76 хүртэл голчтой 0,5-4 м хүртэл урт шугамуудыг уурдаж цэвэрлэн буцаан битүүмжлэх	удаа	5	
109	Ф76-108 мм хүртэл голчтой 0,5-4 м хүртэл урт шугамуудыг уурдаж цэвэрлэн буцаан битүүмжлэх	удаа	6	
110	Аваарийн насосууд ВПУ-н насос задлах засах угсрах	удаа	1	
111	Тосны прокачка хийх	удаа	12	
112	Маслоотбойникт үзлэг хийж засварлах / 1-р холхивч тал /	ш	1	
113	Маслоотбойникт үзлэг хийж засварлах / 2,3-р холхивч тал /	ш	1	
114	МЦНасос бүрэн задалж засварлах, төвлөрүүлэлт хийх.	ш	1	
10. Турбины туслах тоноглолын засвар. Конденсатор.				
115	Усны камерийн люкнүүдийг нээх ба хаах	ш	8	
116	Усны камерийн таг /хавтас/ авах буцааж тавих	ш	4	
117	Конденсаторын усны камер ба самбарын цэвэрлэгээ	удаа	2	
118	Конденсаторын усны гуулин хоолойг шинээр солих ажлыг хийж гүйцэтгэх.	ш	2266	
119	Конденсаторын усны орох, гарах шугамд заглушка тавих, авах	ш	8	
120	Усны камерийн хаг хусмыг механик аргаар цэвэрлэх	ш	4	
121	Конденсаторын хоолойн нягтыг шалгаж гэмтэл устгах	удаа	1	
122	Үндсэн конденсатын шугамд үзлэг хийж шаардлагатай бол хэсэгчлэн солих.	м	6	Ф159*6
123	Усны том самбарт шинээр жийрэг бэлтгэх	ш	4	
124	Конденсаторын боолтнуудын гуулин шайбыг шалгаж шаардлагатайг нь солих	ш	136	
125	Конденсаторын хоёр талын хавтасны м24, м27 мм шпилка,гайк солих	ш	200	80%-г солих
126	Конденсаторын түвшин тохируулагч болон түвшний шилэнд засвар хийх	ш	1	
127	Конденсаторын агаарын цамцыг хэсэгчлэн солих /Ф159мм-н эжектор луу ордог /	цаги раг	2	



128	Конденсаторын тогооны эргэлтийн усны орох, гарах хаалтуудыг задалж үзлэг засвар хийх.	ш	4	бүрэн зогсолтоор /Ру16 Ду400/
129	Конденсаторын тогооны эргэлтийн усны орох, гарах шугамын агаар гаргагч, хаялага, юүлэгч хаалтыг засварлах	ш	6	Ру16 Ду50-2ш Ру16 Ду25-4ш
<b>11. Эжектор, ПНД-гийн засвар</b>				
130	Үндсэн эжекторыг задлаж үзлэг засвар хийх	ш	2	
131	Эжекторын гуулин хоолойг бүрэн солих. Нягтыг шалгах	ш	192	Ф12/10мм
132	Эжекторын гарах , тойруу хаалтанд үзлэг хийж шаардлагатай бол шинээр солих.	удаа	2	Ру16 Ду80-2ш
133	Эжекторын гарах , тойруу шугам хоолойг шинээр солих./ ф60/	м	6	
134	ПНД-д үзлэг засвар хийж	удаа	1	
135	Туслах эжекторыг задлаж үзлэг засвар хийх, доод дээд жийрэг солих, сопло бөглөрхий эсэхийг шалгах	удаа	1	
136	Эжекторын агаарын 2 хаалтанд үзлэг хийж засварлах.	ш	2	
<b>12. ӨДХ-ын засвар</b>				
137	Халаагчийн усны орох ба гарах фланцыг тайлж авах. /М24-ын 16ш шпильк/	ш	16	
138	Крышканы боолтуудыг тайлж авах. /М22-ын 80ш/ Боолтуудыг шинээр солих /70%/	ш	80	
139	Отсосын шугамыг солих	м	35	Ф32мм
140	Халаагчийн зүрхэвчийн геометр хэмжээсүүдийг авч зурагтай нь харьцуулан шалгах	ком	2	
141	Зүрхэвчийг крышка, коллектоос демонтаж хийж авч бэлтгэх./4а/	ком	1	
142	Зүрхэвчийг шинээр ороож бэлтгэх./4а/ ф32*4-500м	ком	1	Ф32х4мм
143	Шинэ зүрхэвчийг крышка, коллекторт угсарч бэлэн болгох.	ком	1	
144	Цахилгаан гагнуураар гагнасан холбоосуудад металл лабораторийн шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулах, үл тэнцсэн хэсгийг огтолж цэвэрлээд дахин гагнах	удаа	1	
145	ӨДХ№4а-н усны дотор, гадна коллекторуудыг солих	удаа	1	Ф108,159мм
146	Зүрхэвчийг усаар шахаж шалгах /туршилтын даралтаар/	удаа	2	
147	ӨДХ№4а,б-н тэжээлийн усны орох, гарах шугам хоолой болон булангуудад металлын шинжилгээ хийлгэж, шаардлагатай бол хэсэгчлэн солих./ф219 булан 2ш солих/	м	12	Ф108,219мм
148	ӨДХ-ийн отсосын шугам, хэмжүүрийн анхдагч хаалтуудад үзлэг хийж бөглөрхий эсэхийг шалгаж засварлах.	ш	4	Ф32 Ру25 Ду32
149	ӨДХ-ийн конденсатын Ф60мм-ийн шугам болон булан тэмлэгт 18 хүртэл бүрэн сольж дулаалах.	м	30	Ф60мм
150	ӨДХ-ийн уурын хаалтанд үзлэг засвар хийж, шаардлагатай бол солих	ш	1	Ру25 Ду200
151	ӨДХ-ийн тэжээлийн усны 6вп4, 7вп4, 8вп4 хаалтуудыг задалж засварлах.	ш	3	Ру100 Ду200
<b>13. Хувирсан усны насосны засвар.</b>				
152	КЭН4а, КЭН4б насосанд бүрэн их засвар хийх (задлах, үзлэг засвар хийх, угсрах )	ш	2	

153	КЭН4а, КЭН4б шахах, сорох хаалт, буцаахгүй клапанд үзлэг засвар хийх	ш	6	Ру10 Ду100.150
154	КЭН4а ажлын дугуй шинээр солих	ш	2	
155	КЭН4а, КЭН4б сорох,шахах шугамд үзлэг хийх. Нягт шалгах	м	8	ф 159 мм
156	Хөргөлтийн усны шугам солих /сантехникийн монтажаар/ ф15-25мм хүртэлх оценковой хоолойгоор	м	10	
157	Хөргөлтийн усны вентилүүдийг солих /сантехникийн монтажаар/ ф15-25мм хүртэлх оценковой хоолойгоор	ш	10	Ру10 Ду15
158	Насосны төвлөрүүлэлт хийж тохируулах.	удаа	2	
159	КЭН4а, КЭН4б агаарын шугамандүзлэг хийж засварлах.шаардлагатай бол шинээр солих /ф32мм/	м	10	
<b>14. Хаалт арматур, шугам хоолойн засвар.</b>				
160	Хурц уурын шугам 1-р үе дренаж,2-р үе дренаж,агаар гаргагч	ш	6	Ру100 Ду32-4ш Ру100 Ду20-2ш
161	Зогсоох хаалтны дренаж	ш	4	Ру16 Ду15-4ш
162	Тогоо юүлэгч хаалт ,	ш	2	Ру16 Ду80-2ш
163	Гар рециркуляц,регуляторын өмнөх,дараах	ш	3	Ру64 Ду32-3ш
164	ПНД орох,гарах,тойруу /усны/	ш	3	Ру16 Ду100-3ш
165	Бүлэг дренаж 1.2ата,8/13ата,ПНД /уурын/	ш	5	Ру25 Ду25-1ш Ру100 Ду32-2ш Ру16 Ду15-2ш
166	Отбор дренаж 1.2ата,8/13 ата ,их бие/уурын/	ш	3	Ру100 Ду32-2ш Ру100 Ду25-1ш
167	ӨДХ тэнцүүлэгч хаалт,буцаахгүй клапан,юүлэгч,отсос	ш	6	Ру20 Ду50-2ш Ру100 Ду32-1ш Ру100 Ду20-3ш
168	Эжекторын анхдагч хаалт засварлах.	ш	2	Ру100 Ду32-2ш
169	1.2ата уурын хаалт болон хамгаалах клапанг засварлах.	ш	3	Ру25 Ду600 Ду200 бүрэн зогсолтоор
170	8/13 ата уурын хаалтууд болон хамгаалах клапанг засварлах.	ш	2	Ру25 Ду300 Ду150 бүрэн зогсолтоор
171	Стопорный клапаны фланецийн жийрэг, бүлэг клапаны буух хоолойн жийрэгийг зэс жийрэг болгох	ш	10	
172	8/13-н отборын цахилгаан хаалтанд засвар хийх.	ш	1	Ру25 Ду300 бүрэн зогсолтоор
173	8/13 ата уурын хамгаалах клапан,ПВД-н уурын хамгаалах клапан барьдаггүй тул шинээр солих.			Ру25 Ду200 Ру40 Ду80
174	Өндөр даралтын халаагчийн конденсатын шугам,буцаахгүй клапан хаалтыг /1ш/ бүрэн солино. Ф60мм	м	40	Ру40 Ду50
175	Генератор хөргөлтийн усны хаалтнуудад үзлэг хийх	ш	4	Ду150мм

176	Хөргөлтийн усны фильтр, түүний орох, гарах, тойруу хаалтанд үзлэг хийж засварлах	ш	3	Ду150мм
177	Хөргөлтийн усны фильтрийн шүүрийг солих.Хэмжээ 600х400мм	ш	1	Нерж лист 6мм
178	МО-ын хөргөлтийн усны орох гарах хаалтанд үзлэг засвар хийж шаардлагатай бол солих	ш	4	Ду50мм
<b>15. Дулаалгын ажил.</b>				
179	Дулаалгыг задлаж буулгаж авах ( турбины разъем, зогсоох клапан, бусад арматур шугам гэх мэт.)	м2	8	
180	Буулгасан материалаас хэрэгтэйг ялгах	м2	4	
181	Дулаалсан гадаргууд жижиг засвар хийж тэгшлэх.	м2	4	
182	Дулаалга хийсэн гадаргууд өнгө шавар хийх	м2	8	
183	Эрдэс хөвөнгөөр дулаалга гүйцээж хийх.	м2	8	
184	Дулаалга хийхэд зориулан эрдэс хөвөнгөөр газар дээрээс нь авсан подушка хийх	м2	8	
185	Бэлтгэсэн подушкаар дулаалга хийж нэг талаас төмөр тороор хааж бэхлэх шавах.	м2	8	
186	Турбины арьсыг генераторын хамт өнгө ялган будах.	м2	20	
187	Уурын шугамын төмөр дулаалга солих	м	10	
<b>Их засварын үед анхаарч ажиллавал зохих зүйлс</b>				
188	Стопорный клапаны фланецийн шпильк, гайка үүрний резьбаг шалгаж засварлах.	удаа	1	
189	Генераторын ротор, турбины роторыг авч явж баланс хийх. Тээвэрлэлтийн зардлыг төсөвт суулгаж өгөх.	удаа	1	
190	1, 2, 3-р холхивчийн доргио буулгаж хэвийн болгоход анхаарах	удаа	1	Эргэлт нэмэх үед ихэсдэг
191	8/13 ата уурын хамгаалах клапан, ПВД-н уурын хамгаалах клапан барьдаггүй тул анхаарах	удаа	1	

Хянасан: Инженерийн албаны дарга.....*А.Оюу*..... Х.Алтангэрэл

..... ИА-ны Техник хяналтын инженер.....*Т.Ор*..... Б.Долгорсүрэн

..... Турбин цехийн дарга.....*М.Сүх*..... Ц.Хишигсүрэн

Ажлын эзэлхүүн гаргасан: Турбины засварын инженер.....*Л.Мянгат*..... Л.Мянгат

ТГ№4-ИЙН ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ТАЙЛБАР.

№	Үзүүлэлт	Тайлбар
1	Үндэслэл	“Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм”-ийн 1-р бүлэг, 1.6.5-р заалтын дагуу хийгдэх ПТ-12-35/10 маркийн турбины ээлжит их засвар.
2	Турбины марк тип, дугаар	ПТ-12-35/10 маркийн 4-р турбин.
3	Байршил	Турбин цехийн заланд
4	Үүрэг зориулалт	Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэнэ.
5	Хийгдэх ажлын товч тайлбар	<ol style="list-style-type: none"> <li>1. Бэлтгэл ба төгсгөлийн ажлууд</li> <li>2. Тохируулгын болон хамгаалалтын системийн засвар</li> <li>3. Уур хуваарилах байгууламжийн засвар</li> <li>4. Эргэвчүүдийн засвар. +(1,2,3,4-р холхивчийг шинээр цутгах)</li> <li>5. Гол эргүүлэх байгууламжийн засвар</li> <li>6. Муфтыны засвар</li> <li>7. Роторын засвар. +(турбины болон генераторын динамик балансыг суурин машин дээр шалгаж, тохируулах)</li> <li>8. Тосны системийн засвар. +(1,2,3-р маслоотбойникийн хуучин ускиийг сугалж шинээр суулгах)</li> <li>9. Конденсацийн системийн тоноглолуудын засвар. +(конденсаторын гуулин хоолой солих, конденсаторын агаарын цамц солих, үндсэн конденсатын шугам солих, эжекторын гуулин хоолой солих, эжекторын орох гарах шугам хоолойг солих)</li> <li>10. Сэргээн халаагчийн засвар. +(ПВД-ийн нэг зүрхэвчийг шинээр ороож солих, усны дотор, гадна коллекторуудыг солих, ПВД-ийн конденсатын шугам солих, отсосын шугам солих)</li> <li>11. Уур, ус, тос, дренажийн шугам хоолойн хаалт арматуруудын засвар</li> <li>12. Дулаалгын засвар зэрэг.</li> </ol>
6	Их засварыг гүйцэтгэхэд ашиглах норм ба дүрэм	1.Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм. 2.Уур, халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм.
7	Ажил гүйцэтгэж эхлэх хугацаа:	2024.05.15
8	Ажил гүйцэтгэж дуусах хугацаа:	2024.08.15

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ  
НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. Ажил дуусгах хугацаа: **“Ашиглахгүй”**
2. Бараа, ажил, үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: **“Ашиглахгүй”**
3. Байгаль орчинд нөлөөлөх байдал: **“Ашиглахгүй”**
4. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: **“Ашиглахгүй”**

## **V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ**

Маягт 1. Тендер илгээх

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
  - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
  - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [*“санал болгоно”* эсхүл *“санал болгохгүй”* гэж бичих]. [*Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих*].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [*ажлын 30 ба түүнээс дээш өдрийн тоо*] өдрийн хугацаанд хүчинтэй байна.<sup>1</sup>
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бараа, үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.

---

<sup>1</sup> Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,*

*эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,*

*албан тушаал, гарын үсэг,*

*байгууллагын тамга, тэмдэг]:*

*Хаяг:*



Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	<i>["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нэгийг бичих]</i>

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Тендерт оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].*

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

#### Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:
  - 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
  - 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
  - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
  - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
  - 1.1.7. “Ажил” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
  - 1.1.8. “Ажлын талбай” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
  - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
  - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
  - 1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

- |         |  |
|---------|--|
| Тайлбар | 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:   |
|         | 1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.   |
|         | 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.   |
|         | 1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана. |
|         | 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.   |
|         | 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.   |

#### ХОЁР. ЗАХИАЛАГЧ

- |                        |         |   |
|------------------------|---------|---|
| Захиалагчийн үүрэг     | нийтлэг | 2.1. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.   |
|                        |         | 2.2. Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.  |
|                        |         | 2.3. Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна. |
| Захиалагчийн төлөөлөгч |         | 2.4. Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.   |
|                        |         | 2.5. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягад заана.  |
|                        |         | 2.6. Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.                   |
| Талбайд зөвшөөрөл      | нэвтрэх | 2.7. Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.                     |
|                        |         | 2.8. Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.               |

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

- |                                       |   |   |
|---------------------------------------|---|---|
| Гүйцэтгэгчийн үүрэг                   | нийтлэг   | <p>3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.</p> <p>3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.</p> <p>3.3. Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.</p> <p>3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.</p> |
| Гүйцэтгэгчийн төлөөлөгч               | <p>3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.</p> <p>3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.</p> |   |
| Техникийн болон ажлын талбайн өгөгдөл | <p>3.11. Захиалагч нь ажлын талбайн байр зүйн, геологийн, гидрогеологийн, цаг уурын болон байгаль орчны нөхцөлийн талаарх, өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.</p>  |   |
| Ажлын талбайн харуул хамгаалалт       | <p>3.12. Гүйцэтгэгч нь зөвшөөрөлгүй этгээдийг ажлын талбайд оруулахгүй байхаар зохион байгуулна.</p> <p>3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбайг хамгаалах, талбайд ажиллагсад болон зорчигчийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай газруудад гэрэлтүүлэг тавих, хашаа барих, харуул хамгаалалттай холбогдон гарах зардлыг хариуцна.</p>   |   |

- |                                |   |
|--------------------------------|---|
| Хог, хаягдал ба нөхөн сэргээлт | 3.14. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбайд саад болох хог хаягдал болон цаашид ашиглагдахгүй болсон бараа материал, эд зүйл, тоног төхөөрөмж, машин механизмыг өөр газарт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажлын талбайг цэвэр байлгана.  |
|                                | 3.15. Гүйцэтгэгч нь ажлын талбайд авчирсан аюултай материалуудыг зохих ёсоор хадгалж, устгана.  |
|                                | 3.16. ГЕН-ийн 3.14-3.15-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнтэй холбоотой аливаа үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна.   |
| Археологийн болон бусад олдвор | 3.17. Ажлын талбай дээрээс олдсон археологийн болон бусад олдвор (бүх чулуужсан амьтан, ургамлын үлдэгдэл, зоос, үнэт зүйлс, бусад эртний олдвор, геологийн болон археологийн ач холбогдол бүхий зүйлс гэх мэт бусад) олдсон тохиолдолд захиалагчид мэдэгдэн, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө. |
|                                | 3.18. Гүйцэтгэгч олдворыг гэмтэхээс сэргийлж зохих арга хэмжээ авна.  |
| Аюулгүй байдал                 | 3.19. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.   |
|                                | 3.20. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.   |
|                                | 3.21. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.  |
|                                | 3.22. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.   |
|                                | 3.23. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.   |
|                                | 3.24. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.   |
|                                | 3.25. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.   |

#### ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

- |            |  |
|------------|--|
| Ажил эхлэх | 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.   |
|            | 4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.                     |
|            | 4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын |



- үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.
- 4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.
- Хугацаа сунгах 4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
- 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;
- 4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;
- 4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;
- 4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.
- 4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.
- 4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.
- 4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
- Ажлын явцын тайлан 4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.
- 4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

#### ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- Гэрээний үнэ 5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.
- 5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.

- |                   |  |
|-------------------|--|
| Урьдчилгаа төлбөр | 5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно. |
| Төлбөрийн нөхцөл  | 5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.   |
|                   | 5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.  |
|                   | 5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.                                |
|                   | 5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.           |
|                   | 5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.   |
|                   | 5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.  |
|                   | 5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.  |

#### ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

- |                       |           |  |
|-----------------------|-----------|--|
| Урьдчилгаа баталгаа   | төлбөрийн | 6.1. ГЕН-ийн 5.4-т заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ.  |
| Гүйцэтгэлийн баталгаа |           | 6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.  |
|                       |           | 6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна: <ul style="list-style-type: none"> <li>6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;</li> <li>6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;</li> <li>6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.</li> </ul> |
|                       |           | 6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.   |

- 6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.
- 6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.
- Чанарын баталгаа
- 6.7. Ажлын чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.
- 6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно.
- 6.9. ГЕН-ийн 6.7-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
- 6.10. Баталгаат хугацаанд ажилд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.
- 6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.
- 6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
- Баталгаат хугацаа
- 6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.
- 6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

#### ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

- Бусдад учруулсан хохирлыг арилгах
- 7.1. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.
- 7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.
- Захиалагчийн эрсдэл хүлээх
- 7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
- 7.3.1. ажлын үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;
- 7.3.2. гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;

- 7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас ажил, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;
- 7.3.4. Захиалагчийн зураг төслийн алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.
- 7.4. Ажлын доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.
- 7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.
- 7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.
- 7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
- 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

#### НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ

- Доголдлыг арилгах илрүүлэх, 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн ажил, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.
- 8.2. Захиалагчийн төлөөлөгч ажлын явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.
- 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.
- 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
- 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.
- 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.

- |                        |  |
|------------------------|--|
| Далд доголдол          | 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.                       |
| Зураг төслийн доголдол | 8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.             |
|                        | 8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна. |
|                        | 8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.   |

#### ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- |                          |   |
|--------------------------|---|
| Захиалагч гэрээг цуцлах  | 9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно: <ul style="list-style-type: none"> <li>9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын 5 хоног ажлын талбайг орхисон;</li> <li>9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;</li> <li>9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;</li> <li>9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;</li> <li>9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;</li> <li>9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;</li> <li>9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.</li> <li>9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.</li> </ul> |
|                          | 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.   |
| Гүйцэтгэгч гэрээг цуцлах | 9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно: <ul style="list-style-type: none"> <li>9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;</li> <li>9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;</li> </ul>  |

- 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.
- Гэрээг цуцлах журам
- 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
- 9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
- 9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.
- Гэрээг цуцалсны дараах төлбөр
- 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
- 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
- 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
- 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
- 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

## АРАВ. БУСАД ЗААЛТ

- Мэдэгдэл
- 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
  - 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
  - 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
  - 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
    - 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
    - 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
  - 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
  - 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
  - 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
- Төлөөлөгч өөрчлөгдөх
- 10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.
  - 10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
  - 10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.
  - 10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.
- Ажилд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл
- 10.12. Талууд ажлын чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.
  - 10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.

- 10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.
- 10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- Гэнэтийн давагдашгүй шинжтэй байдал буюу хүчний онцгой нөхцөл 10.16. Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
- 10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
- 10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
- 10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.
- Оюуны өмчийн эрх зөрчих 10.20. Ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
- Алданги 10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
- 10.22. Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
- 10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.



Маргаан шийдвэрлэх

- 10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 10.26. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 4.1.	Ажил эхлэх хугацаа: <b>2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр</b> Ажлыг дуусгаж ашиглалтанд хүлээлгэн өгөх хугацаа: <b>2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр.</b>
ГЕН 4.2.	Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: <b>Тендерийн саналын хамт ирүүлнэ.</b>
ГЕН 4.9.	Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: <b>Тендерийн саналын хамт ирүүлнэ.</b>
ГЕН 5.2.	Үнийн тохируулга: <b>“Хийхгүй”</b>
ГЕН 5.4.	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: <b>“Үгүй”</b> .
ГЕН 5.6.	Төлбөр төлөх хугацаа: <b>Эцсийн төлбөрийг гэрээ дүгнэсэн акт гарснаас хойш 60 хоногт төлнө.</b> <b>Ажлын явцад хэсэгчилсэн гүйцэтгэлээр хэсэгчилсэн төлбөрийг олгож болно. Ажлын гүйцэтгэлийн болон төлбөрийн хувийг гэрээгээр зохицуулна.</b>
ГЕН 6.1.	Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: <b>Үгүй.</b>
ГЕН 6.7.	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: <b>“Шаардана”</b> Чанарын баталгааны хэмжээ: <b>Гэрээний үнийн дүнгийн 5 хувь</b>
ГЕН 6.13.	Баталгаат хугацаа: <b>Ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш 365 хоног.</b>
ГЕН 7.5.	Даатгал: <b>Ажлын онцлогийг харгалзан гарч болох бүх эрсдэлийг гүйцэтгэгч хариуцна.</b>
ГЕН 10.21.	Захиалагчийн төлөх алдангийн хувь: <b>10%</b> Алдангийн хувь: Гүйцэтгээгүй ажлын дүнгээс хоног тутамд <b>0.1 хувь</b>
ГЕН 10.22.	Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: <b>10%</b> Алдангийн хувь: Гүйцэтгээгүй ажлын дүнгээс хоног тутамд <b>0.1 хувь</b>

## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн нэрийг бичих] (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Ажил” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч [Гүйцэтгэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
  - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
  - 3.6. Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
  - 3.7. Техникийн тодорхойлолт;
  - 3.8. Ажил гүйцэтгэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:

Цахим шуудан:

4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024.02.07**  
Тендер шалгаруулалтын төрөл: Ажил  
Тендер шалгаруулалтын нэр: **ТГ№ 4-ийн их засвар.**  
Тендер шалгаруулалтын дугаар: **ДДЦСТ/20240102089**  
Нийт төсөвт өртөг: **385,575,261.00 ( гурван зуун наян таван сая таван зуун далан таван мянга хоёр зуун жаран нэг) төгрөг**  
Тендер шалгаруулалтын арга: Нээлттэй

1. **“Дарханы Дулааны Цахилгаан Станц” ТӨХК** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **“Үгүй”**
3. Тендерийг **2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 10,30 цаг**–аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 11,00 цаг**-т нээнэ.
4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **“Зөвшөөрөхгүй”**
5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“Эрхгүй”**
6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 өдрийн хугацаанд хүчинтэй байна.
7. Тендерийн баталгаа шаардах эсэх: **“Тийм”**.

Тендерийн баталгааны дүн: **1,927,877(нэг сая есөн зуун хорин долоон мянга найман зуун далан долоо) төгрөг.** Тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.

8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **“Үгүй”**
9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: **“Үгүй”**
10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Дархан-Уул аймаг, Дархан сум, 15-р баг, үйлдвэрийн район,  
“Дарханы Дулааны Цахилгаан Станц” ТӨХК. Утасны дугаар: 70373126,  
Цахим шуудангийн хаяг: darhanpp@mongol.net